



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ” СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2028 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 9/19

Бор-Өндөр сум

### Хөрөнгө бүртгэх тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоолын хавсралтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг эхийн хандиваар авсан 2,000,000 (хоёр сая) төгрөгийн балансын үнэтэй, хавсралтад дурдсан хөрөнгийг үндсэн хөрөнгөд, 5,600,000 (таван сая зургаан зуун мянга) төгрөгийн балансын үнэтэй, 5 нэр төрлийн хавсралтад дурдсан хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд тус тус орлого авч, данс бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан хөрөнгийг холбогдох дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу орлого авч, данс бүртгэлд бүртгэхийг нягтлан бодогч (Б.Анхчимэг), үндсэн хөрөнгийг бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг нярав (Т.Түвшинжаргал), өмч хамгаалах байнгын зөвлөл (С.Мөнхцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН УҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.АМАРЖАРГАЛ